



**БУЛГАН АЙМАГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас: 7034-2680, Факс: 7034-2565
Цахим шуудан: www.info@bulgan.gov.mn
Цахим хуудас: www.bulgan.gov.mn

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

2022-09-29 № 01/116

танай ны № т

Г Зөвлөмжийн хэрэгжилт
хүргүүлэх тухай

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлж байна. Үүнд:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Байгууллагын эзэмшилд байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртгөө бүрэн нэхсен үндсэн хөренгийн ашиглалтын хугацаа болон үнийг жил бүрийн эцэст шинэчлэн тогтоож, аймгийн Орон нутгийн өмчийн газарт хянуулж, тайлан бүртгэлд тусгаж ажиллахыг төсвийн захирагч нарт албан тоотоор үүрэг болгосон.

2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмэлт. үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

Төсөвт байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны эрхийг үүсгэхдээ зардлын эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллаж байна. Боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын нэмэлт эх үүсвэрийг улсын төсвийн урсгал зардлын дансанд төвлөрүүлж тусгай хөтөлбөр зориулалтаар харьялах төсвийн ерөнхийлөн захирагч эрх нээж ажиллаж байгаа болно.

3. Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ын 4.5 дахь заалтыг мөрдөж ажиллах

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг урт, богино хугацаагаар ангилан бүртгэх боломжтой нягтлан бодох бүртгэлийн программаар хангаж, сангийн хяналтын зөвлөлийн эрх, үүргийн хэрэгжилтэнд хяналт тавьж, журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт албан тоотоор үүрэг болгосон.

4. AO670250 01/269 БУА-2022/01/НА-СТА-ТЕЗ Сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага. (Аймгийн нөөцийн газар)

2022 оны 6 дугаар сарын 23-нд хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит Х хуралдаанаар Аймгийн нөөцийн газрыг татан буулгаж Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй орон нутгийн өмчт компанид нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар нэгтгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилсон байна. Аймгийн нөөцийн газрын зарим өр, авлагатай холбогдох хууль хяналтын байгууллагын хяналт шалгалт дуусаагүй, эхний хагас жилийн байдлаар тооллого, тооцоо эцэслээгүй, хаалтын баланс гараагүй, татан буулгахтай холбоотой бэлтгэл ажил хангдаагүй тул хоёр газрыг нэгтгэх ажил 12 дугаар сар хүртэл хойшлогдоод байна.


5. AO670253 01/270 БУА-2022/01/НА-СТА-ТЕЗ Зөрчил арилгах тухай ("Битачи" ХХК-хүүхдийн тоглоомын авлага, Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй авлага)

2022 оны 9 сарын 19-ний байдлаар Битачи ХХК-иас авах авлагын үлдэгдэл 9,6 сая төгрөг байна. Оны эхний үлдэгдэл 39,3 сая төгрөгийн авлагаас 29,7 сая төгрөгийг барагдуулсан байна. Тэшиг 1,8 сая, Хутаг-Өндөр 3,1 сая, Булган сум 1-р цэцэрлэг 2,9 сая, 2-р цэцэрлэг 1,9 сая төгрөгийн тоглоомын авлагатай байна. Битачи ХХК нь цар тахлын улмаас бараа бутээгдэхүүн хил дээр saatаж байна гэдэг тайлбарыг удаа дараа өгч ажлыг удаашруулж байна.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж барагдуулах ажлыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 81 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх санг Хоршоо хөгжүүлэх сан болгон өөрчлөн баталсан. Зээлийг урт богино хугацаагаар ангилан бүртгэж, хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгоод байна.

6. AO670253 02/271 БУА-2022/01/НА-СТА-ТЕЗ Зөрчил арилгах тухай (Шилэн данс)

2022 оны эхний 8 сарын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд аймгийн төсвийн өрөнхийлөн захирагчийн нийт 101 мэдээллийг бүрэн оруулж, үүнээс 17 мэдээллийг хугацаа хоцроосон байна.





БУЛГАН АЙМАГИЙН ЗАСАГ ДАРГА

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас: 7034-2680, Факс: 7034-2565
Цахим шуудан: www.info@bulgan.gov.mn
Цахим хуудас: www.bulgan.gov.mn

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2022-09-29 № 01/1115.
танай ны № т

Г Зөвлөмжийн хэрэгжилт хүргүүлэх тухай

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлж байна. Үүнд:

1. Дамжуулан зээлдүүлэх гэрээний зээлийг барагдуулахад онцгой ач холбогдол өгч, тусгай төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

Булган аймагт гадаад зээлийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр 2003-2019 оны хооронд гурван төсөл арга хэмжээг нийт 12,8 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлсэн ба тодорхой шалтгаан, орон нутгийн төсвийн нөөц бололцоо зэргээс шалтгаалж 2021 оныг хүртэл эргэн төлөгдөөгүй болно. Сангийн яамнаас Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний дагуу улсын төсөвт төвлөрүүлэх үндсэн болон хүүтийн төлбөрийг орон нутгийн төсөвт тусгаж төвлөрүүлэхээр төлөвлөж эхлээд байна. Энэ оны төсөвт 276,0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас 56,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шилжүүлж, 208.0 сая төгрөгийн зээлийн төлбөрийг аймгийн санхүүгийн дэмжлэгээс шууд суутган аваад байна.

Аймгийн төсөв санхүүгийн боломж, Булган мээж ХХК-ний санхүүгийн чадавхи, өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж зээлийн хувь, алдангиас чөлөөлөх асуудлыг холбогдох яам, Засгийн газар, УИХ-д тавьж шийдвэрлүүлж өгөхийг хүсэлтийг Сангийн сайдад уламжилсан.

2. Төсвийн захирагч нарын дотоод хяналтыг сайжруулах, холбогдох журмын дагуу дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг боловсруулан, гүйцэтгэлд нь хянат тавих, сумдын санхүүгийн албаны үүрэг оролцоог нэмэгдүүлэх

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/20 тоот захирамжаар төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг батлуулж төлөвлөгөөний дагуу Бүрэгхангай, Могод, Сэлэнгэ сум, Хялганат тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж холбогдох зөвлөмжийг өгч ажиллалаа.

6322010357

3. Төсвийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тоогоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1-д заасан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба чиг үүргээ хэрэгжүүлж Өрийн удирдлагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу өрийн удирдлагын хэрэгжилтэд дотоод аудит хийх

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанад аудитын зөвлөмжийг хүргүүлж аймагт хэрэгжиж буй дамжуулан зээлдүүлэх гэрээний хэрэгжилтэд дотосд аудит хийлгэсэн. Тайланг хавсаргав.

4. OL-3713Mon-1N дугаартай гэрээний 1.1.10-д заасны дагуу төсөл хэрэгжиж дууссан тул ашигласан зээлийн хэмжээгээр эргэн төлөлтийн хуваарийг зээлдүүлэгчтэй тооцоо нийлж шинэчилж батлах

OL-3713Mon-1N дугаартай “Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл”-өөр Булган аймгийн төвд шинээр барьсан цэвэрлэх байгууламжийн 2022 оны зээлийн хүүгийн төлбөрийг хойшлуулах саналыг Сангийн яамны төрийн нарийн бичгийн даргад албан тоотоор хүргүүлээд байна.

5. Газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх

Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа оны төсвийн төслийг 8 сард Сангийн яаманд хянуулахад газрын дуудлага худалдааны орлогыг өмнөх жилүүдийн дунджаар тооцож төлөвлөдөг. Сумын ИТХ нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 12 дугаар сард хэлэлцэн баталдаг нь газрын дуудлага худалдааны орлогыг бодитой төлөвлөхөд хүндрэл учруулж байна.

6. ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгааныг тодорхойлон бэлтгэн ирүүлж байх

2021 оны ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаар дотоод аудит хийлгэж холбогдох тайлан, дүгнэлтийг хүргүүлж ажилласан. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгааныг төсөл, арга хэмжээ тус бүрээр гарган төсвийн гүйцэтгэлийн тайланда нэгтгэн өгч байгаа болно.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

